



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 6/07

Мөрөн

**Б.Баттулгыг ажилд томилох тухай**

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 24, 25 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Батдоржийн Баттулгыг Эрүүл мэндийн газрын жолоочоор 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн туршилтын 6 сарын хугацаатайгаар томилсугай.

2. Эрүүл мэндийн газрын жолооч Б.Баттулгын үндсэн цалинг ТҮ-3-1 шатлал, бусад нэмэгдэл хөлсийг зохих журмын дагуу томилогдсон өдрөөс эхлэн цалинжуулахыг Эрүүл мэндийн газрын Ахлах нягтлан бодогч (Х.Амаржаргалд)-д зөвшөөрсүгэй.

3. Эрүүл мэндийн газрын жолооч Б.Баттулгын ажил хүлээцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын даргад:

Б.Батчимэг

(Эрүүл мэндийн удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүдэд:

Ж.Нансалмаа

(Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн)

Х.Баттогтох

(Хуулийн зөвлөх)

Ж.Эрдэнэчимэг

(Нярав)

Х.Бат-Бэх

(Жолооч)

Э.Эрдэнэ-Уул

(Жолооч)

4. Эрүүл мэндийн газрын жолооч Б.Баттулгатай ажлын байрны тодорхойлолт, үйл ажиллагааны төлөвлөгөө байгуулан ажиллахыг Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн удирдлагын хэлтсийн дарга (Б.Батчимэг), Хүний нөөц хариуцсан мэрэгжилтэн (Ж.Нансалмаа) нарт үүрэг болгосугай

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Хуулийн зөвлөх (Х.Баттогтох)-д даалгасугай.

ДАРГА



М.ҮҮРИЙНБАЯР